



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛД ТАВИХ
ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС ТӨСӨЛ, АРГА
ХЭМЖЭЭ БҮРЭН ХЭРЭГЖИХГҮЙ БАЙНА.

“”ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: ХЭА-2025/06-22-ШТА-ГА

Хэрлэн сум 2025 он



Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор Ж.Ганбаатар

Утас: 70562112 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 92116773 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Эрдэнэбилэг

Утас: 92116770 Цахим хаяг: erdenebilegd@audit.gov.mn

Аудитор Т.Алтаншагай

Утас: 92116768 Цахим хаяг: altanshagait@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

**Аудитыг гүйцэтгэсэн:**

Хэнтий аймаг дахь Төрийн
аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор
Ж.Ганбаатар

Аудитын менежер
Д.Оюунтуяа

Ахлах аудитор:
Д.Эрдэнэбилэг

Аудитор:
Т.Алтаншагай

Аудитын тайлан,
дүгнэлт, зөвлөмжтэй
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах, холбогдох
саналаа өгөхийг хүсвэл
70562112 дугаарын
утсаар харилцана уу.

Аудитын тайланг УАГ-ын
www.open.audit.mn цахим
хуудаснаас үзнэ үү.

Хаяг: Хэнтий аймаг дахь
Төрийн аудитын газар

Хэрлэн сум, 4-р баг,
аймгийн Засаг даргын
Тамгын газрын байр

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	6
БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөлтийн шаардлагад бүрэн нийцүүлэн төлөвлөхгүй байна.	9
1.1. Төсөл, арга хэмжээний зураг төслийг улсын магадлалд хамруулах төлөвлөлтийн шаардлагыг мөрдөхгүй байна.	9
1.2. Өмнөх оноос хэрэгжсэн төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтад бүрэн тусгаж, санхүүжих дүн нь холбогдох журамд нийцсэн байна.....	10
1.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг бүрэн олгож, гэрээний хугацаа хэтрүүлсэн гүйцэтгэгчид алдангийг тооцсон байна.....	11
БҮЛЭГ 2. Захиалагчийн хяналт хангалтгүй хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор 21 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжиж дуусаагүй байхад улсын комиссоос үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авч ашиглалтанд оруулсан байна.	13
2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд тендерийг зохион байгуулаагүй, төсвийн тодотголоор батлагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд нэмж тусгаагүй байна.....	13
2.2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт хангалтгүй хэрэгжиж байгаагаас ажил нь бүрэн хийгдэж дуусаагүй байхад ашиглалтад хүлээн авч байна.....	15
2.3. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.	17
БҮЛЭГ 3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийгмийн салбарын барилга байгууламжийн их засварын ажил үр дүнтэй хэрэгжсэн байна.	17
3.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж байна.....	17
3.2. Орон нутгийн хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг нийгмийн салбарын их засварт зарцуулсан нь үр дүнтэй болсон байна.....	18
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:	19
ДҮГНЭЛТ: 20	
ЗӨВЛӨМЖ:	21

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 04 дугаар сарын 17

Дугаар А/18

Чингис хот

Г Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Худалдан авах ажиллагааны газарт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т үүрэг болгосугай.
3. Аудитаар өгсөн албан шаардлагыг тогтоосон хугацаанд, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, түүний биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Аюурбуны/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Сүнгээ/-д, Худалдан авах ажиллагааны газрын дарга /Г.Лхагвахатан/-д тус тус зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР



232501018

	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОБГ	Онцгой байдлын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХА	Харьцуулалтын арга
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орон нутгийн хөрөнгө оруулалтыг баталсан мэдээлэл	8
Хүснэгт 2	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг хуульд нийцүүлсэн байдал	11
Хүснэгт 3	Аймгийн ГХБХБГ-ийн хяналтын инженерүүдийн хяналт хэрэгжүүлдэг, төсөл, арга хэмжээний судалгаа,	12
Хүснэгт 4	Орон нутгийн өмчид бүртгэсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний мэдээлэл	16

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Худалдан авах ажиллагааны цахим системд тендерийг мэдээлсэн байдал	14

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Дэлгэрхаан сумын ЕБС-ийн цахилгааны өрөө, номын сангийн өрөөний хаалга	16
Зураг 2	Биндэр сумын ЕБС-ийн дотуур байрны өрөө хоорондын хана	16
Зураг 3	Политехник коллежийн дотуур байрны ариун цэврийн өрөө	16

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь заалт, Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2024 оны А/108 дугаар тушаалыг үндэслэн гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэв.
Аудитын зорилт	“Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д аудит хийж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга болон холбогдох албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэв. Уг зорилтын хүрээнд дараах дэд асуудлуудад аудитыг чиглүүлэн хийж гүйцэтгэлээ. Үүнд: • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журамд нийцүүлэн төлөвлөсөн эсэх, • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх, • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, төлөвлөсөн хугацаанд гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх,
Аудитын хамарсан хүрээ	Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд болон аймгийн ОНӨГ, аймгийн ХААГазар, аймгийн ГХБХБГазар зэрэг төрийн байгууллагууд, хөрөнгө оруулалтыг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй,	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол улсын төрийн аудитын стандарт MNS 6817-7:2020, Гүйцэтгэлийн аудитын зарчим, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн баримт материал нягтлан шалгах зэрэг судалгааны арга зүйг ашигласан.
Шалгуур үзүүлэлт	Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав. Үүнд: • Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, • Төсвийн тухай хууль, • Төрийн хэмнэлтийн тухай хууль, • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,

**Аудит хийсэн багийн
бүрэлдэхүүн,
хугацаа**


Хүндрэл бэрхшээл

- үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Барилгын тухай хууль,
 - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
 - “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого,
 - Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
 - Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
 - Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”,
 - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны гуравдугаар хуралдааны 02 тоот тогтоол, 2024 оны хорин долоодугаар хуралдааны 08 тоот тогтоол, хорин есдүгээр хуралдааны 02 тоот тогтоол,
 - Барилгын, хот байгуулалтын сайдын 2019 оны 108 дугаар тушаалаар баталсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"
 - Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд,
 - Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд,
- Аудитыг газрын дарга, Тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа хэрэгжүүлэн ахлах аудитор Д.Эрдэнэбилэг, аудитор Т.Алтаншагай нар 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 04 дүгээр сарын 18-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хэнтий аймгийн ИТХ-ын 2023 оны 12 сарын 25-ны XIII дугаар хуралдааны 02 тоот тогтоолоор аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг баталж, түүнд 2 удаа тодотгол хийн шинээр эхлэх 20, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 16, нийт 16,102.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 төсөл, арга хэмжээг 8,742.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Хүснэгт 1



Орон нутгийн 2024 оны төсөвт шинээр эхлүүлэх 5,425.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл, арга хэмжээг 4,358.3 сая төгрөгөөр санхүүжихээр тусгасан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд нийтдээ 14,329.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосноос 2024 онд 8,187.1 сая төгрөгийн 34 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Тайлант оны эцэст хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 32 төсөл, арга хэмжээний 14,559.0 сая төгрөгийн хөрөнгийг 43 байгууллага санхүүгийн тайланд тусган бүртгэсэн байна.

БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөлтийн шаардлагад бүрэн нийцүүлэн төлөвлөхгүй байна.

1.1. Төсөл, арга хэмжээний зураг төслийг улсын магадлалд хамруулах төлөвлөлтийн шаардлагыг мөрдөхгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд барилга байгууламжийн 2, их засварын 10, тоног төхөөрөмжийн 6, зураг төсөв боловсруулах 2, нийт 20 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Хөрөнгө оруулалтын 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан шинээр эхлүүлэх 2 төсөл, арга хэмжээ хэрэгжих газрын эрхийг сумын Засаг даргын Захирамжаар холбогдох байгууллагад эзэмшүүлсэн байна.

Шинээр эхлэх 1 төсөл, арга хэмжээ нь эрчим хүч, дулаан, цэвэр, бохир ус зэрэг инженерийн шугам сүлжээний техникийн нөхцөл авч, 1 төсөл, арга хэмжээ нь техникийн нөхцөл шаардагдахгүй хөрөнгө оруулалт байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын 14,707.6 сая төгрөгийн 26 их засвар, барилга угсралтын төсөл, арга хэмжээ батлагдсанаас 10,648.6 сая төгрөгийн 10 барилга угсралт, их засварын төсөл, арга хэмжээ 2023 оноос хэрэгжиж эхэлсэн байна.

Шинээр хэрэгжүүлэх 4,059.0 сая төгрөгийн 12 барилга угсралт, их засварын төсөл, арга хэмжээний зураг төсөл, хяналтын төсөв нь улсын магадлалаар батлагдсан бол 397.2 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний зураг төсөл, хяналтын төсөв улсын магадлалаар батлагдаагүй байна.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журмын 3.2.2.¹-д заасан шаардлагыг хангахгүй “Багийн төвийн барилга /Биндэр сум, Баян-Өндөр баг, Галшар сум Оч баг/ төсөл, арга хэмжээний улсын магадлалд оруулах зардалыг төсөвт суулгаагүй шалтгаанаар, тус журмын 3.2.3.4.²-д их засварын төсөл, арга хэмжээнд зураг төсөл, хяналтын төсвийг заавал магадлалд хамруулах шаардлага тавигдаагүй шалтгаанаар “Иргэдэд үйлчлэх нэгдсэн төвийн засвар /Хэрлэн сум/, 1-р багийн төвийн засвар /Хэрлэн/” зэрэг 397.2 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний зураг төсөл, хяналтын төсвийг улсын магадлалаар батлуулаагүй байна.

Гэхдээ дээрх 3 төсөл, арга хэмжээний зураг төсөл, хяналтын төсвийг зураг төсвийн мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан боловсруулж, хяналтын төсвийг хийлгэсэн байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар 7,618.1 сая төгрөгийн 7 барилга угсралтын ажил, 7,089.5 сая төгрөгийн 19 их засварын, 766.9 сая төгрөгийн 6 тоног төхөөрөмж, 627.5 сая төгрөгийн 4 зураг төсвийн ажлыг 2024 онд хэрэгжүүлэхээр баталснаас 35 төсөл, арга хэмжээ хэрэгжиж, 1 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

“Сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /Галшар, Цэнхэрмандал, Баян-Овоо сумд/” 150.0 сая төгрөгийн ажлын худалдан авах ажиллагааг tender.gov.mn цахим

¹ барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх,

² тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох баримт бичигт үндэслэсэн байх

системээр нээлттэй зарласан боловч гүйцэтгэгч оролцоогүйн улмаас хэрэгжээгүй байна.

Хөрөнгө оруулалтын нийт төсөл, арга хэмжээнд шинээр баригдах барилга угсралтын 2, их засвар хийх, тоног төхөөрөмж худалдан авах, зураг төсөл боловсруулах 10 төсөл, арга хэмжээ нь урсгал зардал, орон тоо тооцох шаардлагагүй байна.

1.2. Өмнөх оноос хэрэгжсэн төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтад бүрэн тусгаж, санхүүжих дүн нь холбогдох журамд нийцсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр эхлүүлэх 5,425.9 сая төгрөгийн 20 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 2024 онд 4,358.3 сая төгрөгийг баталсан байна.

Дээрх төсөл, арга хэмжээнээс улсын магадлал хийлгэх 4,059.0 сая төгрөгийн 12 барилга угсралт, их засварын ажлаас 9 ажлын зураг, төслийг улсын магадлалаар батлуулан, төсвийг 4,009.7 сая төгрөгөөр хянуулсан байна.

Харин 3 ажлыг бага зардлаар тухайн ажлыг гүйцэтгэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журамд их засварын ажлыг улсын магадлал хийлгэх шаардлагыг тусгаагүй зэрэг шалтгаанаар боловсруулсан зураг төсөл, хяналтын төсөвт улсын магадлал хийлгээгүй нь төсөвт өртөг нэмэгдэх, ажлын тоо хэмжээг өөрчлөгдөх зэргээр хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулах эрсдлийг үүсгэсэн байна.

Иргэдэд үйлчлэх нэгдсэн төвийн засвар /Хэрлэн сум/, ОБГ-ын сургалт, сурталчилгааны төвийн байр, тохижилт, 1-р багийн төвийн засвар /Хэрлэн/-ын ажлуудын зураг төсөл улсын магадлалаар батлагдаагүй байна.

Тайлант онд хөрөнгө оруулалт, их засварын 22 төсөл, арга хэмжээний улсын магадлалаар батлагдсан 14,653.6 сая төгрөгийн төсөвт өртгийг 643.2 сая төгрөгөөр бууруулан 14,010.4 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах зорилттой “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 17.1.5³-д заасан шаардлагад нийцсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өмнөх оноос он дамжин хэрэгжиж байгаа 16 төсөл, арга хэмжээг дуусгах 4,384.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг бүрэн тусгаж баталсан байна.

Хөрөнгө оруулалтын 2 төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны ... Захирамжаар Мөрөн, Баян-Овоо сумын Засаг дарга нарт эрх шилжүүлж, тухайн ажлууд бүрэн хэрэгжсэн нь сумд төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бүрэн боломж байгааг харуулж байна.

Мөрөн сумын ЗДТГ-ын 114.9 сая төгрөгийн “Ахмадын байрны засвар, тоног төхөөрөмж”, Баян-Овоо сумын ЗДТГ-ын 120.0 сая төгрөгийн “Нэгдсэн халаалтын зуухыг шинэчлэх” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна.

³ 17.1.5.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилт нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар төлөвлөх.

Тайлант онд хэрэгжиж дуусах 530.1 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ тайлант онд хэрэгжиж дуусалгүй он дамжсан нь аймгийн ЗДТГ-аас шаардлагатай дүгнэлтийг гаргаагүй, аймгийн ОНӨГ-аас худалдан авах ажиллагааг хугацаа алдаж зарласан, гүйцэтгэгч ажлаа төлөвлөж чадаагүй зэргээс шалтгаалж байна.

Биндэр суманд байгуулагдах “Цанын баазын зураг төсөл” ажлын инженер геологийн дүгнэлтийг гаргаагүйгээс улсын магадлалаар батлагдаагүй, Хэрлэн сумын “Гэр хорооллын дунд жишиг гудамж байгуулах” ажлын ХАА-г хугацаа хоцроож зохион байгуулснаас гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэх графикт хугацаа зөрчигдөж ажил зогссон байна.

Орон нутгийн 2024 оны хөрөнгө оруулалты ажлыг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5⁴-д заасныг баримтлан шинээр эхлэх 5,425.9 сая төгрөгийн 20 төсөл, арга хэмжээг 1-2 жилд багтаан хэрэгжүүлж дуусгахаар төсвийг баталсан байна.

Хүснэгт 2

д/д	ТАХ-ны тоо	Төсөвт өртөг	2024	2025
1	6	1,211.1	1,211.1	
2	14	4,214.8	3,147.2	1,067.6

Эх сурвалж: Хэнтий аймгийн ИТХ-ын №02 тоот тогтоол

1.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг бүрэн олгож, гэрээний хугацаа хэтрүүлсэн гүйцэтгэгчид алдангийг тооцсон байна.

Тайлант онд нийт 34 төсөл, арга хэмжээнд санхүүжилтийг гүйцэтгэлээр бүрэн олгосон ба үүнээс гүйцэтгэгчид 7,668.7 сая төгрөгийг олгож, 2 төсөл, арга хэмжээнд санхүүжилт олгоогүй байна.

Цанын баазын зураг төсөл /Биндэр сум/ инженер геологийн дүгнэлт хийгдээгүйгээс улсын магадлалаар батлагдаагүй, Сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /Галшар, Цэнхэрмандал, Баян-Овоо сумд/-ний худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгч шалгараагүйгээс тайлант онд гүйцэтгэл гараагүй байна.

Улсын комисс ажилласан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж, санхүүжилтийг бүрэн олгосны 2 төсөл, арга хэмжээний санхүүжилт 2024-2025 онд он дамжин санхүүжихээр батлагдсан ч гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр дуусган ашиглалтад өгсөн байна.

Эрүүл мэндийн төвийн их засвар /Баян-Адарга сум/ ажлын үлдэгдэл санхүүжилт 210.0 сая төгрөг, Хэнтий аймаг дахь политехник коллежийн оюутны дотуур байрны барилгын хэсэгчилсэн засварын ажлын үлдэгдэл 74.9 сая төгрөг 2025 онд санхүүжихээр төлөвлөгдсөн байна.

Он дамжин хэрэгжих дээрх 2 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл 2025 онд олгогдохоос шалтгаалан ажлын эцсийн гүйцэтгэлийг холбогдох маягтын дагуу гаргаагүй байна.

⁴ 29.3.5. Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;

Тайлант онд гүйцэтгэлээр 17 төсөл, арга хэмжээний зураг, төсвийн 398.2 сая төгрөгийн зардлыг зураг төсөв зохиогчид олгож, 3 төсөл, арга хэмжээний 6.6 сая төгрөгийг захиалагчийн хяналтын зардалд, 17 төсөл, арга хэмжээний 24.3 сая төгрөгийг зохиогчийн хяналтын зардалд тус тус шилжүүлсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч аймгийн ГХБХБГ нь 2024 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, аймаг, сумын ОНХС-ийн төсөл, арга хэмжээ, сумдтай байгуулсан гэрээ болон “Монголросцветмет” ТӨХК-тай байгуулсан гэрээний дагуу зэрэг нийт 123 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байна.

Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч тус газрын бүтэц, орон тоог Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны “Аймгуудын Газрын харилцаа, хот байгуулалтын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтыг шинэчлэн батлах тухай” №Б/10 тушаалаар Хэнтий аймгийн Газрын харилцаа, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн орон тоог нийтдээ 6 хүнтэй байхаар баталсан байна.

Энэ тушаалаар батлагдсан орон тоогоор төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхэд хүний нөөц дутагдаж байгаагаас барилгын инженер мэргэжлийн 3 хүнийг гэрээт ажилтнаар нэмж ажиллуулан захиалагчийн хяналтыг гүйцэтгүүлсэн байна.

Хүснэгт 3

д/д	Төрөл	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг /сая.төг/	1 хяналтын инженерт ногдох ТАХ-ны тоо
1	УТХО	28	240,097.9	21
2	ОНХО	25	13,942.9	
3	ОНХС	41	16,462.4	
4	АЗС	5	1,489.5	
5	Сумдын ХО	19	2,841.3	
6	Монголросцветмет ТӨХК	5		
	НИЙТ	123	274,834.0	

Иймд тус газрын хяналтын инженерүүдийн хяналт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо их, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх объектүүд нь сумдад тархан байрладаг нь тогтмол хяналт тавих, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийн цаашид үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлэхэд анхаарах нь зүйтэй.

Улсын комисс хүлээн авсан 32 төсөл, арга хэмжээний 29 нь гэрээний хугацаанд хэрэгжиж дууссан бол 3 төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч ажил гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөөг мөрдөөгүйгээс хугацаанд нь дуусгаагүй байна.

“Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны их засвар /Батноров сум, Бэрх тосгон/”, “Сургуулийн дотуур байрны засвар /Биндэр сум/”, “Хан-Хэнтий сургуулийн дотуур байрны барилгын засвар /Хэрлэн сум/” төсөл, арга хэмжээ нь гэрээний хугацаанд хэрэгжүүлж дуусгаагүй тул гүйцэтгэгчид 9.2 сая төгрөгийн алданги тооцон суутган авсан байна.

Харин тайлант онд дуусгахаар гэрээ байгуулсан 2 төсөл, арга хэмжээ дуусгаагүй бөгөөд 2025 онд хийж дуусгахаар гэрээг сунгасан байна.

“Цанын баазын зураг төсөл /Биндэр сум/” орон нутгийн төрийн байгууллагаас инженер геологийн дүгнэлтийг хийгээгүйгээс тус ажил улсын магадлалаар батлагдах боломжгүй болсон, “Гэр хорооллын дунд жишиг гудамж байгуулах /Хэрлэн сум/” ажил тодотголоор баталж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулсан боловч гэрээний хугацаа дуусахаас өмнө хүйтний улирал эхэлж хөрөнгө оруулалтын үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй тул ажлыг зогсоон дараа онд шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Иймд гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд тендерт оролцохдоо гаргасан календарчилсан төлөвлөгөөг мөрдөж ажиллахад тавих хяналтыг сайжруулан, гэрээний хугацаанд ажлыг бүрэн дуусган ашиглалтад оруулах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. Захиалагчийн хяналт хангалтгүй хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор 21 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжиж дуусаагүй байхад улсын комиссоос үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авч ашиглалтанд оруулсан байна.

2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд тендерийг зохион байгуулаагүй, төсвийн тодотголоор батлагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд нэмж тусгаагүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар тайлант онд шинээр хэрэгжих 5,425.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас 15-ийг НТШ аргаар, 4-ийг ХА-аар зохион байгуулсан байна.

Харин “Аймгийн Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж” худалдан авах 1 техник, тоног төхөөрөмжийг 64.7 сая төгрөгөөр Төрийн худалдан авах газрын цахим дэлгүүрээс худалдан авсан байна.

Хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх 20 төсөл, арга хэмжээнээс 16 ажлыг аймгийн Шилэн дансны тухай хуулийн 6.1.1⁵-т заасны дагуу 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан бол тодотголоор батлагдсан 4 төсөл, арга хэмжээ тус төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.


Худалдан авах ажиллагааг зохион байгуулах 5 үнэлгээний хороог хугацаанд нь байгуулаагүйгээс тендер хугацаа хоцорч төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байна,

Shilendans.gov.mn цахим системд мэдээлэгдсэн худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан 14 ажлын ХАА-г хугацаанд нь, 6 төсөл, арга хэмжээ 1-4 сар хоцроон зохион байгуулсан нь холбогдох байгууллага, албан тушаалтнууд цахим хуудасны шилэн данс хэсэгт байршуулсан төлөвлөгөөг мөрдөхгүй, хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Төсөл, арга хэмжээний эрхийг сумдад шилжүүлэхэд ХАА зохион байгуулах ажилтнуудын эрх дууссан, хүний нөөц хангалтгүй байгаа нь “Ахмадын байрны засвар, тоног төхөөрөмж /Мөрөн сум/” ажлын тендерийг төлөвлөгөөнд тусгагдсанаас 27 хоног хэтэрхэд нөлөөлжээ.

⁵ 6.1.1. тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

Дүрслэл 1



“Нэгдсэн халаалтын зуухыг шинэчлэх /Баян-Овоо сум/ шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан нас барж хугацаа алдсанаас 105 хоног хэтэрсэн,

Тайлант онд улсын комисс ажилласан 32 төсөл, арга хэмжээнээс 9 төсөл, арга хэмжээний гэрээний дуусах хугацааг 1-3 сараар сунган нэмэлт гэрээ байгуулсан байна.

Аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын ажил хариуцсан хэлтсийн дарга, мэргэжилтнүүд “Хөдөлмөр халамжийн үйчилгээний газрын тоног төхөөрөмж”, “Эмнэлгийн машин” төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээг худалдан авах ажиллагааг зарлахаар төлөвлөгөөнд заасан хугацаанаас хойш хүргүүлсэн, “ОБГ-ын сургалт, сурталчилгааны төвийн байр, тохижилт” төсөл, арга хэмжээний үнэлгээний хороог байгуулаагүйгээс худалдан авах ажиллагаа 28-51 хоногоор хугацаа хэтэрсэн байна.

Төлөвлөлтийн шаардлагад тусгасан улсын магадлалаар батлагдсан байх шаардлагийг хангаагүй “4 дүгээр сургуулийн дотуур байрны дээвэр болон хэсэгчилсэн засвар /Хэрлэн сум/” төсөл, арга хэмжээний улсын магадлалаар зураг төсөл, хяналтын төсөв батлагдалгүй удсанаас ХАА 31 хоногоор хэтэрсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төсвийн тодотголоор нэмж батлагдсан “Гэр хорооллын дунд жишиг гудамж байгуулах /Хэрлэн сум/” ажлын ХАА-г зохион байгуулж гүйцэтгэгчийг шалгаруулсан ч тайлант онд хэрэгжүүлж дуусахад хугацаа хангалтгүй байснаас он дамжин хэрэгжиж байна.

Мөн дараа онд он дамжин хэрэгжиж байгаа “ОБГ-ын сургалт, сурталчилгааны төвийн байр, тохижилт” төсөл, арга хэмжээ 2024-2025 онд хэрэгжихээр төлөвлөгдөн батлагдсан бол бусад 3 ажил тайлант онд хэрэгжиж дуусахаар батлагдсан ч хүйтний улиралд бетон цутгалтын ажил хийгдэх боломжгүй тул зогссон, худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгч шалгараагүй, зураг төсөл, хяналтын төсөв улсын магадлалаар батлагдаагүй шалтгаанаар он дамжин хэрэгжихээр гэрээг сунгасан байна.

“Гэр хорооллын дунд жишиг гудамж байгуулах /Хэрлэн сум/” төсөл, арга хэмжээ төлөвлөхдөө хэрэгжих хугацааг хангалттай байхаар тооцоогүйгээс уг ажил зогссон байна.

Тайлант онд шинээр хэрэгжсэн 20 төсөл, арга хэмжээнээс 4,059.0 сая төгрөгийн барилга угсралт, их засварын 12 төсөл, арга хэмжээ магадлалаар батлагдсан зураг төслийн дагуу хэрэгжсэн байна.

Мөн тоног төхөөрөмж нийлүүлэх 766.9 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэгдсэн байна.

Тайлант онд батлагдсан нийт 36 төсөл, арга хэмжээнээс 34 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 8,187.1 сая төгрөгийг олгосон нь гэрээний дүнгээс хэтрээгүй байна.

Үлдсэн 2 төсөл арга хэмжээ нь шаардлагатай инженер геологийн дүгнэлтийг хийлгээгүй, худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгч шалгараагүй шалтгаанаар хэрэгжээгүй нь төлөвлөлтийг бүрэн хийгээгүй, шаардлагатай судалгааг хангалттай хийгээгүйтэй холбоотой байх тул цаашид анхаарч ажиллах шаардлагатай.

“Цанын баазын зураг төсөл /Биндэр сум/” ажлын инженер геологийн дүгнэлт гараагүйгээс зураг, төсөв улсын магадлалаар батлагдаагүй, “Сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /Галшар, Цэнхэрмандал, Баян-Овоо сумд/” ажлыг гүйцэтгэгч шалгараагүйгээс тус тус хэрэгжээгүй.

Тайлант онд олгосон санхүүжилтийн 7,668.7 сая төгрөгийг төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд, 398.2 сая төгрөгийг зураг төсвийн зардалд, 24.3 сая төгрөгийг зохиогчийн хяналтын зардалд, 6.6 сая төгрөгийг Захиалагчийн хяналтын зардалд холбогдогч байгууллагуудад бүрэн шилжүүлсэн байна.

Харин гэрээний хугацаанд төсөл, арга хэмжээг дуусгаагүй 3 гүйцэтгэгчид 9.2 сая төгрөгийн алдангийг суутган авч, ашиглалтад орсон 7 төсөл, арга хэмжээний 80.0 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд чанарын баталгаат хугацаанд тооцон байршуулсан байна.

2.2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт хангалтгүй хэрэгжиж байгаагаас ажил нь бүрэн хийгдэж дуусаагүй байхад ашиглалтад хүлээн авч байна.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж дууссан нийт 32 төсөл, арга хэмжээнээс зураг төсвийн 2 төсөл, арга хэмжээ, тоног төхөөрөмжийн 6 төсөл, арга хэмжээг хүлээн авах комисс томилон хүлээн авсан бол бусад 24 барилга угсралт, их засварын ажлуудыг Монгол улсын Засгийн газрын 2021 оны 212 тоот тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу улсын комисс ажилласан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжсэн 16 төсөл, арга хэмжээнээс 14 төсөл, арга хэмжээ нь 2023 онд байнгын ашиглалтад оруулсан бол тайлант онд 18 төсөл, арга хэмжээнд улсын комисс томилогдон ажилласан байна.

Улсыг комисс ажилласан 3 төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч бүрэн дуусган ашиглалтад өгсөн нь захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлбэл төсөл, арга хэмжээний хэрэгжилт сайн байхыг харуулж байна.

Гүйцэтгэгч компани календарчилсан төлөвлөгөөг мөрдөж ажилласан 3 төсөл, арга хэмжээг улсын комисс хүлээн авч ашиглалтанд оруулсан нь захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Си Эйч Би Жи ХХК-ны гүйцэтгэсэн “Гүйлтийн зам, хөл бөмбөгийн талбайн зүлэг, тохижилт” /Хэрлэн сум/, “Төв цэнгэлдэх хүрээлэнгийн доторх хүний суудал, суудлын суурийн ажил”, Жизи номадс ХХК-ны “Захирагчийн ажлын албаны их засвар” /Хэрлэн сум, Өлзийт тосгон/ ажлууд бүрэн хийгдсэн байна.

Монгол улсын Засгийн газрын тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.2.4⁶ -т техникийн комисс ажиллах тохиолдлыг заасан бөгөөд Хэнтий аймагт ашиглалтад орсон бүтээн байгуулалт, их засварын төсөл, арга хэмжээнд техникийн комисс ажиллах шаардлагатай төсөл, арга хэмжээг хэрэгжээгүй байна.

Улсын комисс ажилласан 21 төсөл, арга хэмжээг үүрэг даалгавар өгч, чанарын баталгааг гаргуулан ашиглалтад оруулсан байна. /Хавсралт 1/

Эдгээрээс “Эрүүл мэндийн төвийн засвар /Баянмөнх сум/”, “1-р багийн төвийн засвар /Хэрлэн/” ажлууд баталгаат хугацаанд бороо орсноос дусаал гоожиж хийгдсэн засварын чанарыг алдагдуулах, үр дүнгүй болгох эрсдэлтэй байгааг чаналын баталгаат хугацаанд засварлуулах нь дүйтэй.

Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврыг 18 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч хэрэгжүүлж ажилласан бол 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч хэрэгжүүлээгүй байна.

“Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Дэлгэрхаан сум/, “Сургуулийн дотуур байрны засвар /Биндэр сум/” ажлын тоо хэмжээнд тусгагдсан ажил бүрэн хийгдээгүй байхад улсын комисс ажиллан ашиглалтад оруулсан,



Зураг 1



Зураг 3

“Хэнтий аймаг дахь политехник коллежийн оюутны дотуур байрны барилгын хэсэгчилсэн засвар”-ын ажлын тоо хэмжээг бүрэн тооцоолоогүйгээс дутуу орхигдсон ажлыг улсын комиссын үүрэг даалгавраар хийж гүйцэтгэхээр зэрэг болгосныг биелүүлээгүй тул үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах нь зүйтэй.

⁶ Барилгын тухай хуулийн 32.1.5-д заасан барилга байгууламж болон энэ дүрмийн 3.2-т заасан шийдвэрээр барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллахаас өмнө барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага техникийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилно;

Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 8.2.2⁷-т улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй бол ашиглалтад хүлээн авахгүй байхаар тусгасан боловч төсөл, арга хэмжээнд ажилласан улсын комисс байнгын ашиглалтад хүлээн авч дүрмийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Мөн барилга техникийн хяналтын улсын байцаагч төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналтын тогтмол хийж гүйцэтгэхэд аймгийн ГХБХБГ цаашид анхаарч ажиллах нь зүйтэй юм.

2.3. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд хэрэгжиж дууссан 32 төсөл, арга хэмжээг бүртгэх талаар аймгийн ЗДТГ-аас 2025.01.07-ны №3/39 албан тоотойр аймгийн Орон нутгийн өмчийн газарт, Орон нутгийн өмчийн газраас 2025.01.13-ны №09 тоот албан бичгээр холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.

Санхүүгийн тайланд бүртгэгдсэн хөрөнгийн мэдээлэл

Хүснэгт 4

д/д	Төрөл	Тоо	дүн	ХО-д эзлэх хувь
1	Хөрөнгө оруулалт	5	6,777.9	46.6
2	Их Засвар	19	6,834.7	46.9
3	Тоног төхөөрөмж	6	768.9	5.3
4	Зураг төсөв	2	177.5	1.2
	ДҮН	32	14,559.0	100.0

Дээрх нийт 32 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дүнд бий болсон 14,559.0 сая төгрөгийн хөрөнгийг 42 байгууллагын санхүүгийн тайланд тусгах шийдвэр гарган хэрэгжүүлсэн байна.

Эдгээрээс “Соёлын төвийн барилгын их засвар /Хэнтий, Хэрлэн сум, 5-р баг/” ажил 2023 онд Хэрлэн сумын Соёлын төв шийдвэр гарган бүртгэлд авсан бөгөөд санхүүжилтийн үлдэгдлийг олгосон, “Залуучуудын сургалт спорт хөгжлийн төвийн зураг төсөв /Хэнтий, Хэрлэн сум/” иж бүрэн зураг төсвийг аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалтын дансанд тус тус бүртгэсэн байна.

БҮЛЭГ 3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийгмийн салбарын барилга байгууламжийн их засварын ажил үр дүнтэй хэрэгжсэн байна.

3.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж байна.

⁷ 8.2.2. энэ дүрмийн 5.1, 6.1-д заасан шаардлага хангаагүй, 8.1-д заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй тохиолдолд татгалзсан дүгнэлт.

Аймгийн цэнгэлдэх хүрээлэнгийн бүтээн байгуулалт, зам талбайн тохижилт /6,808.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ/ нь нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулах боломжийг бүрдүүлж тогтмол ашиглагдаж байна.

Сумдын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, иргэдэд үйлчлэх төв, баг, тосгоны байрны засвар зэрэг 7,089.5 сая төгрөгийн 19 төсөл, арга хэмжээ нь хүүхэд сурах орчныг нэмэгдүүлсэн, иргэдэд үйлчлэх нөхцлийг сайжруулсан байна.

Мөн 766.9 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээгээр нийлүүлэгдсэн автомашин, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаж байна.

3.2. Орон нутгийн хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг нийгмийн салбарын их засварт зарцуулсан нь үр дүнтэй болсон байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын нийт төсөл арга хэмжээний 8 нь төрийн захиргааны салбар, 6 нь дэд бүтцийн салбар, 3 нь байгаль орчин, нийгмийн хамгааллын салбар, 19 нь боловсрол, эрүүл мэндийн салбарын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан ба нийт төсөл, арга хэмжээний 90% нь бүрэн хэрэгжиж ашиглалтад орсон байна.

Үүнээс 21 төсөл, арга хэмжээ буюу 7,089.5 сая төгрөгийг боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын барилгын засварлах, автомашины хангалтыг сайжруулахад зарцуулсан нь орон нутгийн хөрөнгө оруулалтын 43.6 хувийг эзэлж байна.

Дэд бүтцийн салбарт 7,244.4 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн нь нийт хөрөнгө оруулалтын 45.0 хувийг эзэлж байна.

Үүнд Баянмөнх, Баян-Адарга, Мөрөн сумдын Эрүүл мэндийн төвд их засвар хийж, Бор-Өндөр, Галшар, Дархан, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал болон аймгийн Нэгдсэн эмнэлэгт автомашины хангалт хийж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, эмчлүүлэгчдийн ая тухтай эмчлүүлэх нөхцлийг сайжруулжээ.

Мөн Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Хэрлэн сумын Хэрлэн-4, Хан-Хэнтий ЦС болон Бэрх тосгоны ЕБС-ийн биеийн тамирын болон хичээлийн байр, Хэрлэн-4, Биндэр, Хан-Хэнтий ЦС, Политехник коллежийн дотуур байрыг засварлан хүүхдийн сурах орчныг сайжруулж, ая тухтай суралцах нөхцлийг бүрдүүлсэн байна.

Нийгмийн салбарт ажиллагсдын амьдрах орчныг сайжруулах хүрээнд Дархан сумын ЕБС-ийн багш, ажилчдын 4 айлын орон сууцыг засварлаж, иргэд соёлын үйлчилгээг авах орчныг сайжруулах хүрээнд Баянхутаг сумын Соёлын төвд их засварыг хийжээ.

Орон нутгийн 2024 оны хөрөнгө оруулалтын 88.6 хувийг нийгмийн салбар дэд иргэдийн амьдрах орчныг сайжруулах дэд бүтцийн салбарт үр дүнтэй зарцуулсан байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:


**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23117
Утас/Факс: (976) 7056 2412
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2025. 04. 18 № 5/853
танай _____ -ны № _____ -т

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

ХЭА-2025/06-22-ШТА-ГА кодтой "Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн аудит, ХЭА-2025/06-22-ШТА-НА кодтой "Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.
Тайлангийн төсөлд тусгах саналгүй болно.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Д.БАЯРХҮҮ



233071110

Аудитад хамрагдагч байгууллагаас тайлангийн төсөлд тусгах санал ирүүлээгүй тул тайланд өөрчлөлт ороогүй.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тухайн жилийн 8,742.7 сая төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэл 93.6 хувь, тухайн онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн 34 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 94.1 хувьтай байна.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтар 2024 онд Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар /Дэлгэрхаан, Цэнхэрмандал, Хэрлэн сумын Хан-Хэнтий" ЦС, 4 дүгээр сургууль/, дотуур байрны барилга /Жаргалтхаан, Биндэр, "Хан-Хэнтий" ЦС, 4 дүгээр сургууль, Политехник коллеж/, ЕБС-ийн спорт залны засвар / Бэрх тосгоны ЕБС/, Эрүүл мэндийн төвийн засвар /Баянмөнх, Мөрөн, Баян-Адарга/, ЭМТ-ийн яаралтай дуудлагын автомашиныг шинэчлэх /Бор-Өндөр, Галшар, Дархан, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал/, Дархан сумын ЕБС-ийн багш, ажилчдын байрыг засварлах зэрэг төрийн албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулахад зарцуулсан байна.
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулах 5 үнэлгээний хороог хугацаанд нь байгуулаагүй, ажилтнуудын АЗ гэрчилгээний хугацаа дууссанаас тендер хугацаа хоцорч зохион байгуулагдаж төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байна,
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс нь нийт төсөл, арга хэмжээний 87.5 хувийг Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 8.2.2 дахь заалтыг зөрчин үүрэг даалгаврын биелэлтийг хяналгүйгээр хүлээн авч ашиглалтанд оруулсан байна.
- Аймгийн ГХБХБГ нь захиалагчийн хяналтыг хангалтгүй гүйцэтгэж байгаагаас төсөл, арга хэмжээ хугацаандаа бүрэн хэрэгжихгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Д.Аюурбунь-д

- Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд заасан хугацаанд зохион байгуулах боломжтойгоор үнэлгээний хороог байгуулж байх,

Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Г.Лхагвахатан-д

- Аймгийн хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулах АЗ сертификаттай ажилтнуудын нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах,

Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга Б.Сүнгээ-д

- Төсөл, арга хэмжээний хяналтын төсөвт тусгагдсан ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу хэвийн ашиглалтын хугацаанд гарсан зөрчлийн шалтгаан нөхцлийг тухай бүрд нь шалган тогтоож, улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан шуурхай засварлуулж барилга объектыг хэвийн ашиглах нөхцлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах,

ҮАГ-ААР ДАМЖУУЛАН УЛАМЖИЛЖ САНГИЙН ЯАМАНД ТАВИХ САНАЛ:

- Монгол улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй их засварын ажлын зураг, төсөвт улсын магадлал хийгддэг байх" заалтыг нэмж тусгуулах

Хавсралт 1

**УЛСЫН КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТЭЭР ХҮЛЭЭН
АВСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Өгсөн үүрэг даалгавар
1	Төв цэнгэлдэх хүрээлэнгийн зогсоолын нэмэлт ажил /Хэрлэн сум/	Зогсоолд нүхтэй блок суурьлуулж ус зайлуулах, гүйцэтгэлийн зургийг мэдээллийн санд оруулах
2	Пүрэвжавын гудамжны авто замыг Цагдаагийн уулзвараас урагш явсан авто замтай холбох зам	корын шинжилгээ авах, дутуу тэмдгийг гүйцээх, ЦГ-ын автозогсоолын хучилтыг стандартад нийцүүлэх, гүйцэтгэлийн зураг гаргаж мэдээллийн санд оруулах
3	Багийн төвийн барилга /Биндэр сум, Баян-Өндөр баг, Галшар сум Оч баг/	1 ширхэг газан халаагуур, 10 л баллон,
4	Эрүүл мэндийн төвийн засвар /Баянмөнх сум/	Ханын ховхорсон шохой, өрөөний хулдаасыг хана руу наах, наалтыг дахин наах, зарим розетка, унтраалга хийх үед үүссэн ханын гэмтлийг засах, угаалгын өрөөний сул хоолойг бэхлэх, ариун цэврийн өрөөний дээд хэсгийг өнгөлөх,
5	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Дэлгэрхаан сум/	дизель генератор суурилуулах, үүдний халуун хөшиг хийгдэх, цахилгааны өрөөний хаалгийг металл хаалгаар солих, суултуурыг шалтай наах, гадна фасадыг цэвэрлэх, камерын утсыг далдлах, номын сангийн өрөөний хаалга засах, 1 ангийн дутуу гарниз, үдийн цайны хаалга, уурын зуухны дээвэр хагас /жигжиг өрөөний/, хаалганы амалгаа,
6	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны их засвар /Жаргалтхаан сум/	Цонхны силикон хийх, 00 өрөөний плитаны чигжээс хийх,
7	Эрүүл мэндийн төвийн засвар /Хэнтий, Мөрөн сум/	Агшин зуурын халаагчыг бүгдийг залгууртай болгох, бойлуурыг ажиллагаанд оруулах, төрөх өрөөний хаалганы засварыг хийх, дээвэрт урд, хойно 2 решотк хийх
8	Сургуулийн барилгын их засвар /Цэнхэрмандал сум/	цэвэр усны шугам дээр ус зөөлрүүлэгч тавих, гадна бохирын шугмыг шороогоор дүүргэх, 1м хагарсан шил солих
9	Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчдын 4-н айлын орон сууцны барилгын засвар /Дархан сум/	үүдний тамбур доторлох, үлдсэн 2 айлын ханын дотор засал, паркет шалны блинтус дуусгах
10	ХанХэнтий цогцолбор сургуулийн дээврийн засвар /Хэрлэн сум/	Хүзүүвчинд хар цаасаар хучих,
11	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны их засвар /Батноров сум, Бэрх тосгон/	агаар сэлгэлтийн иршиткийг суурилуулах, ус гоожсон дулааны сеткийг солих, бохирын шугамын холболтыг хийх, заалны блентусыг

		модоор солих, гэрэлтүүлгийг хаалттай болгох, босоо эрэгтэй нойлын байрлал буруу, заалны хавтастай хаалга солих, дулаан, цэвэр усны шугамыг дулаалах,
12	4-р сургуулийн цонхны засвар /Хэрлэн сум/	Гадна фасад силикондох, дотор агааржуулалтын хоолой гүйцээх, хаяавч хийх, дутуу металл хавтан хийх, дотор дээвэрт салхивч агаарын хоолой хийх,
13	Иргэдэд үйлчлэх нэгдсэн төвийн засвар /Хэрлэн сум/	Коридорын явган хана угсрах, АЦӨ-ний тоноглолыг угсрах
14	1-р багийн төвийн засвар /Хэрлэн/	Борооноор дээврийн хөндийд дусаал гоожвол битүүлэх, чанарын баталгаа гаргах, хадгаламжийн нэгж бүрдүүлэх
15	Захирагчийн албаны засвар /Хэрлэн, Тахилгат тосгон/	Явган зам цутгах, паркет засварлах, тэргэнцэртэй иргэний зам, тайзны шаланд амалгаа хийх, төв цахилгааны бүрээсэнд хамгаалалт хийх, цонхны ус гоожилтыг зогсоох, шатанд 1 үе нэмэх
16	Соёлын төвийн дээвэр дотор гэрэлтүүлэг болон хэсэгчилсэн засвар /Баянхутаг/	Явган зам цутгах, паркет засварлах, тэргэнцэртэй иргэний зам хийх, шатыг намсгаж нэг үе нэмэх, цонхны ус гоожилтыг зогсоох,
17	Эрүүл мэндийн төвийн их засвар /Баян-Адарга сум/	Угаалгын өрөөний плитаг өөр өрөөнд хийсэн, хүзүүвчийг будах, цонхны силикон наах, хүзүүвчний хана, дээвэр янзлах, угаалгын өрөөнд хулдаас дэвсэх, явган замын цементийг нөхөх, уурын зуухны трубаг ялгаж будах, орох хаалганы шатыг өнгөөр будах
18	Сургуулийн дотуур байрны засвар /Биндэр сум/	Захиалагч, зохиогчийн нэгдсэн дүгнэлт гаргах, улаан журнал дээр гарын үсэг, тамга дутуу, мэргэжлийн байгууллагын үүрэг даалгаврын биелэлт тэмдэглэгдээгүй, барилгын материалын сертификат, лабораторын дүгнэлт байхгүй, хүүхэд хөгжлийн өрөөний хана хоорондыг бөглөж 2 өрөө болгох, будаггүй цонхны тавцанг гүйцээж будах, цонхыг силикондож гүйцээх, цахилгааны холболтыг өрөө бүрт тавьж гүйцээх,
19	Хан-Хэнтий сургуулийн дотуур байрны барилгын засвар /Хэрлэн сум/	Хүзүүвчний хэсэгт хар цаасан хучилт хийх, гэрэл угсралт нэмэх,
20	4 дүгээр сургуулийн дотуур байрны дээвэр болон хэсэгчилсэн засвар /Хэрлэн сум/	Дутуу металл хавтанг хийж гүйцээх, хаяавч бетон хийх, дотор дээвэрт салхивч, агаарын хоолой хийх, гадна фасад силикондох, 00-н өрөөний гэрэл холбох
21	Хэнтий аймаг дахь политехник коллежийн оюутны дотуур байрны барилгын хэсэгчилсэн засварын ажил	00-ын агааржуулалтыг хийх, 00 дуусгах, цонхны тавцанг авч шатны хонгилд хийх, агааржуулалт

Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг,
Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхарт
Утас: +976 70562112
И-мэйл хаяг: khentii@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn